

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2023.10.09-НИЙ ӨДРИЙН
“ЧИГЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ” 56 ДУГААР АЛБАН БИЧГИЙН ДАГУУ ХИЙЖ
ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023.11.13

Баян-Улаан

1. Хоршоо хөгжүүлэх сангийн чанаргүй зээлийг эргэн төлүүлэх аян, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, эргэн төлөгдөөгүй зээлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, шалтгааныг тодруулах:

- Тус ажлын хүрээнд Авилгатай тэмцэх газрын 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 03/10559 дугаар албан бичиг, Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн “Чиглэл хүргүүлэх тухай” 56 дугаар тус тус албан бичгийн хүрээнд сумын ИТХурал болон Засаг даргын үүрэг даалгавараар ажлын хэсэг томилогдон Хоршоо хөгжүүлэх сангийн ТСШХороо болон хяналтын зөвлөлийн ажлуудыг эрчимжүүлж, Хоршоо хөгжүүлэх сангийн чанаргүй зээлийг эргэн төлүүлэх аян, арга хэмжээг 2 удаа үр дүнтэй зохион байгуулж, ХХСангийн эргэн төлөлт болон явцын мэдээллийг ИТХ, БИНХ, олон нийтэд байнгын мэдээлэл хийж, эргэн төлөгдөөгүй зээлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, шалтгааныг тодруулсан бөгөөд 2015 онд Хөдөлмөр халамжийн чиглэлээр ирсэн тоног төхөөрөмжүүдийг тухайн үедээ эргэн төлөгдөхгүй гэж иргэдэд олгосон иргэн Б.Мөнхтөр, С.Гөлөгдулам нарын гутлын машин 1,827,000 төгрөг, хэрээсний машин 1,600,640 төгрөг нийт 3,427,640 төгрөгний тоног төхөөрөмжийг буцаан авсан. Ж.Гэрэлмаагийн 3,420,000 төгрөгний зээлийн хариуцагч эзэн нас барсан тул шүүх хэрэгсэхгүй болгосон. Бусад гэрээний хугацаа бүрэн дууссан зээлүүдээ шүүхийн байгууллага руу шилжүүлэн төлж барагдуулсан бөгөөд 2023 онд шүүхэд хандсан 2 зээлдэгчийн 17,050,0төгрөгний зээл 11 сард бүрэн төлөгдөж дууссан. Гэрээний хугацаа дууссан зээлдэгч Б.Отгонбаярын 9,425,000 төгрөгийн дүнтэй зээлийн материалыг бүрдүүлэн ИХАШШүүх рүү шилжүүлээр болоод байна. Явцын хугацаа хэтрэлттэй байгаа 8 зээлдэгч нарт холбогдох мэргэжилтэн байнгын утсаар ярьж, гэр болон ажлын байран дээр нь очиж албан мэдэгдэл хүргүүлэн, ажиллаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 3 зээлдэгч зээлээ төлсөн бөгөөд тухайн ХХСангийн зээл нь Монгол банкны мэдээллийн санд бүртгэлтэй болсноор зээлдэгч нар зээлээ хугацаанд нь төлөх нь давуу талтай байна.

2. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллах:
 - ИТХ-аар ХХСангийн журмын дагуу 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан хяналтын зөвлөл нь зээлдэгч нар зээлээ зориулалтын дагуу ашиглаж, эргэн төлөлтөө хуваарийн дагуу төлөх, үйлдвэрлэл үйлчилгээгээ явуулж байгаатай 2023 оны 2 дугаар сараас хойш ИТХ-аас гаргасан хяналт шалгалтын удирдамж болон Засаг даргын зөвлөмжийн дагуу Засаг даргын орлогч Т.Хүрэлбаатараар ахлуулсан ажлын хэсгийнхэнтэй хамтран газар тариалан, 2-догч түүхий эд боловсруулах, сүү цагаан идээ боловсруулах, ноос, арьс шир, түүхий эд боловсруулах зэрэг чиглэлээр зээлэнд хамрагдсан 4 хоршоо, 2 ААН, 22 иргэнд хяналт шалгалтыг хийсэн бөгөөд зээлдэгч нар журмын дагуу үйл ажиллагаагаа эрхэлж, үйлдвэрлэл үйлчилгээгээ явуулж өрхийн орлогоо нэмэгдүүлж, шинээр ажлын байр бий болгон амжилттай ажиллан сум болон аймгийн үзэсгэлэн худалдаанд амжилттай оролцож байна.
3. Хоршоо хөгжүүлэх сангаас шинээр олгож байгаа зээлүүдийг сумын хөгжлийн бодлого зорилтдоо нийцүүлэн, оновчтойгоор олголт хийж байгаа эсэхэд хяналтын зөвлөлийг ажиллуулж олон нийтэд мэдээлэх:
 - ХХСангийн зээл олголт хэр шударга, мэдээлэл хэр сайн хүртээмжтэй авч, зээлэнд хамрагдаж байгаа талаар Сумын вейб сайт, нүүр хуудас болон цахим орчинд төсөл хүлээж авах зарыг байршуулах, үзэлээр мэдээлэл хүргэх, сумын багийн хурлуудад мэдээлэл хийх зэргээр олон нийтэд ил тод нээлттэй байгаа эсэх талаар ард иргэдээс “Нээлттэй хаалганы өдөрлөг”-өөр санал асуулга авч ажилласан бөгөөд иргэд ам сайтай 2019 оноос хүү багатай урт хугацаатай ийм зээл байдгийг мэдэж, дамаан ЖДҮҮЭ иргэд хамрагдаж байгаадаа маш сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж байлаа. Харин энэ оноос иргэнд олгохгүй байх нь суманд хүндрэлтэй байна гэсэн санал өгсөн.
4. Хоршоо хөгжүүлэх сангийн зээл олголтын үйл ажиллагаа, зээлийн эргэн төлөлтийн явц байдлын талаар олон нийтэд нээлттэй мэдээлж байх тогтолцоог бүрдүүлэх, байнгын ажиллагаатай байлгах :
 - ХХСангийн ТСШХороо нь төслийн зарын дагуу 30 хоногийн хугацаанд төслүүдийг цахимаар болон цаасаар хүлээн авч ИТХ-ын ТСШХороо хуралдах товын дагуу хуралдаж, сумын хөгжлийн тэргүүлэх чиглэл, нэн

түрүүнд санхүүжүүлэх шаардлага оновчтой төслүүдийг эрэмбэлэн санхүүжилтийг олгон ажиллаж байгаа бөгөөд санал гомдол гараагүй сайн ажиллаж байна. Сумын вейб сайт, нүүр хуудас болон цахим орчинд төсөл хүлээж авах зарыг байршуулах, үзэлээр мэдээлэл хүргэх, сумын багийн хурлуудад мэдээлэл хийх зэргээр олон нийтэд ил тод нээлттэй мэдээлж байна.

5. Хоршоо хөгжүүлэх сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, журмыг зөрчиж төсөл сонгон шалгаруулсан, төслийн хэрэгжилтэд зохих журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй, сумын хөгжлийн бодлого зорилттой уялдаагүй зээлүүдийг буцаан хоршоо хөгжүүлэх санд татан төвлөрүүлж, санг хохиролгүй болгох арга хэмжээг авч ажиллах:

-ХХСангийн журмын дагуу сумын хөгжлийн бодлого зорилттой уялдаатай төслийг хүлээн авч, шалгарсан төслүүдэд зээлийг олгож , хяналт шалгалтыг тогтмол хийж, ИТХуралд тайлагнан ажиллаж байгаа болохоор чанаргүй зээл байхгүй.

2019 оноос хойш жил бүр ХХСангаас /хуучнаар СХСан/ зээл гаргахдаа аймгаас тухайн жилийг ямар зорилтот жил болгон зарласан байна түүнтэй уялдуулан сумын хөгжлийн бодлого, зорилтдоо нийцүүлэн нэн түрээнд дэмжих шаардлагатай ажлын байр шинээр бий болгож байгаа өрхийн болон цехийн үйл ажиллагаанууд , ААН, хоршоодын газар тариалан, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалалт, мод үржүүлэг, хүлэмжийн аж ахуй эрхлэх, эрчимжсэн мал аж ахуй, малын үүлдэр угсаа сайжруулах, тахианы аж ахуй аялал жуулчлал, малын гаралтай түүхий эд, цагаан идээ боловсруулах, уламжлалт аргаар сур суран эдлэл хийх, эсгий гар урлал, ноос, хялгасан урлал, бэлэг дурсгал, гэрийн мод, тавилга, модон эдлэл, хуванцар савны хэрэглээг халах зорилгоор андуу сав, хөхүүр, торх зэргийг үйлдвэрлэж байгаа малчид, иргэд, өвөлжөө хаваржааныхаа 0,01 га газарт малын ногоон тэжээл тариалж байгаа малчид, мөн оёдол эсгүүр, гэрэл зураг, компьютер канон, гэр ахуйн цахилгаан бараа засвар, дугуй засвар, барилгын материал, хэрчсэн гурил, талх нарийн боов зэрэг үйдвэрлэлийн чиглэлээр 2020 онд 150,0 сая, 2021 онд 100,0 сая, 2022 онд 80,0 сая төгрөгний зээлийг тус тус олгосон. 2023 онд “Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх” зорилтот жил болон сумын хөгжлийн тэргүүлэх чиглэлийн дагуу ХХСангаас 2023 онд 7 иргэнд 50,0 сая төгрөгний зээлийг олгосон бөгөөд бүх зээлдэгч нартаа хяналтыг тавьж ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар ХХСанд 63,705,0 сая төгрөг төвлөрөөд байна.

ХХСангийн журамд 2023 оны 10 дугаар сарын 04-нд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан 2023 оны 10 дугаар сарын 27нд 50,0 сая төгрөгний зээл гаргахаар хуралдах байсан боловч ТСШХорооны хурал хойшлогдон төсөл ирүүлсэн 2 иргэнд журмын мэдээллийг хүргэн төслийг буцаан өгсөн. Одоогоор журмын дагуу шаардлага хангасан хоршоо байхгүй байна. ХХСангийн журам болон хоршоотой холбогдолтой хууль, дүрэм, журмын нэмэлт өөрчлөлтүүд, шинэчлэлтийг тухай бүр нь сумын удирдлагууд болон үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч нар төсөл өгөхөөр бэлдэж байгаа ард иргэд, ААН, хоршоодод, 6 багийн БИНХурлуудад давхардсан тоогоор 250 гаруй тараах материал, гарын авлага, төсөл хэрхэн бичих талаар мэдээлэл хийн арга зүйн зөвөлгөө өгч ажиллаж байна.

Газар тариалангийн чиглэлээр зээлэнд хамрагдсан хоршоо иргэдэд хяналт шалгалтыг хийхдээ зээлэнд хамрагдахаар төсөл бичсэн тухайн иргэд болон хоршоо нь өөрийн гэсэн тариалалт хийх газартай эсэх, мөн зээлийн барьцаа хөрөнгө, зээлээ хугацаанд нь төлөх чавдартай эсэхийг очиж газар дээр нь очиж шалгаж, зээлээ олгодог ба хяналтыг байнга хийдэг.





ХХСАНГААС ЗЭЭЛ АВСАН ААН, ХОРШОО, ИРГЭД СУМ АЙМГИЙН ҮЗЭСГЭЛЭН
ХУДАЛДААНД ОРОЛЦОВ.





ХХСАНГИЙН ЗЭЭЛД ХАМРАГДСАН ААН, ХОРШОО, ИРГЭДЭД ХЯНАЛТ ХИЙСЭН
ЗУРГИЙГ ТАЙЛАНД ХАВСАРГАВ.







ТАЙЛАН БИЧСЭН:
ХААТ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН
ХЯНАСАН: ЗАСАГ ДАРГА

Ш.МӨНХСАЙХАН
Б.БААСАН

